



**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2024 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

| | |
|---|----|
| НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ | 2 |
| 1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл..... | 2 |
| 1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл..... | 3 |
| 1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл..... | 4 |
| 1.4 Бодлого, зохицуулалтын орчин..... | 5 |
| ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД | 7 |
| 2.1 Статистик үзүүлэлтүүд..... | 7 |
| 2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд..... | 9 |
| 2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд...10 | |
| 2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд..... | 11 |
| ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | 12 |
| 3.1 Хөрөнгийн бүтцийн талаар..... | 12 |
| 3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар..... | 14 |
| 3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар..... | 14 |
| 3.4 Зээлийн чанарын талаар..... | 15 |
| ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | 18 |
| 4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар..... | 18 |
| 4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар..... | 19 |
| 4.3 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн талаар..... | 19 |
| 4.4 Санхүүгийн бус өр төлбөр..... | 20 |
| 4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар..... | 21 |
| 4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар..... | 21 |
| ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА | 22 |
| 5.1 ХЗХ-дын орлогын талаар..... | 22 |
| 5.2 ХЗХ-дын зардлын талаар..... | 22 |
| 5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар..... | 23 |
| ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | 24 |
| 6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар..... | 24 |

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025.02.10

Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 178 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 ХЗХ буюу 6.8 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 51.1 хувь буюу 91 ХЗХ орон нутагт, 48.9 хувь буюу 87 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо (хот, орон нутгаар)



Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 2 ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох, 4 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 7 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 8 ХЗХ-ны 59 сонгуульт гишүүн (давхардсан тоогоор), 2 ХЗХ-ны хаяг байршлын өөрчлөлт, 7 ХЗХ-ны гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, 2 ХЗХ-ны салбарын гүйцэтгэх захирал болон хаяг байршлын өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

| Он | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024.IV |
|-------------------------|------|------|------|------|---------|
| ХЗХ-ны тоо | 249 | 209 | 196 | 191 | 178 |
| Шинээр олгосон | 14 | - | 7 | 3 | 4 |
| Хүчингүй болгосон | 26 | 40 | 20 | 8 | 17 |
| Түдгэлзүүлсэн | 23 | 12 | 13 | 12 | 4 |
| Сэргээсэн | 6 | 1 | 3 | 1 | 2 |
| ТЗ-ийн хугацаа сунгасан | 49 | 85 | 62 | -* | -* |

*Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2023.01.06-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.

ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 7.2 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бол гишүүдийн тоо дунджаар 1.2 хувиар, тэр дундаа орон нутгийн гишүүдийн тоо 6.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 2: ХЗХ-дын тоо, гишүүдийн мэдээлэл (хот, орон нутаг)

| | 2020.IV | 2021.IV | 2022.IV | 2023.IV | 2024.IV | Дүрсгэл |
|--------------------|---------|---------|---------|---------|---------|-----------|
| Нийт ХЗХ-дын тоо | 249 | 209 | 196 | 191 | 178 | ■ ■ ■ ■ ■ |
| Улаанбаатар | 148 | 116 | 107 | 100 | 87 | ■ ■ ■ ■ ■ |
| Орон нутаг | 101 | 93 | 89 | 91 | 91 | ■ ■ ■ ■ ■ |
| Нийт гишүүдийн тоо | 72,651 | 75,400 | 71,657 | 72,521 | 75,252 | ■ ■ ■ ■ ■ |
| Улаанбаатар | 43,225 | 44,575 | 39,626 | 39,284 | 40,363 | ■ ■ ■ ■ ■ |
| Орон нутаг | 29,426 | 30,825 | 32,031 | 33,237 | 34,889 | ■ ■ ■ ■ ■ |


1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 178 ХЗХ 61 салбар, 623 ажилтан, 75,252 гишүүн (74,938 иргэн, 314 хуулийн этгээд)-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотод Багахангай дүүргээс бусад дүүрэгт 87 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 ХЗХ буюу 13.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдэд төвлөрөл хамгийн их байна.

Монгол Улсын 21 аймагт 91 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлт ороогүй байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2: ХЗХ-дын тархалт



Зураг 1: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2024 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,731 буюу 3.8 хувиар өсөж 75,252-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 54.6 хувь буюу 41,072 нь эмэгтэй, 0.4 хувь буюу 314 нь хуулийн этгээд, үүний 39.5 хувь буюу 124 нь эмэгтэй удирдлагатай байна.

Зураг 3: ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 53.6 хувь буюу 40,363 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 46.4 хувь буюу 34,889 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт (хот, орон нутгаар)




Нийт 178 ХЗХ-ны 30.9 хувь буюу 55 ХЗХ 20-100 гишүүнтэй, 51.7 хувь буюу 92 ХЗХ 101-500 гишүүнтэй, 10.1 хувь буюу 18 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 7.3 хувь буюу 13 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна. 1,001-ээс дээш гишүүнтэй ХЗХ-дын 53.8 хувь буюу 7 ХЗХ Улаанбаатар хотод, 46.2 хувь буюу 6 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 3: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

| Гишүүд (интервалаар) | ХЗХ-ны тоо | Гишүүдийн тоо | Нийт гишүүдэд эзлэх хувь |
|--------------------------|------------|---------------|--------------------------|
| 20-100 гишүүнтэй | 55 | 3,064 | 4.1% |
| 101-500 гишүүнтэй | 92 | 21,680 | 28.8% |
| 501-1,000 гишүүнтэй | 18 | 13,251 | 17.6% |
| 1,001-ээс дээш гишүүнтэй | 13 | 37,257 | 49.5% |
| Нийт | 178 | 75,252 | 100.0% |

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 13 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 49.5 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



1.4 Бодлого, зохицуулалтын орчин

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хадгаламж, зээлийн хоршооны салбарт мөрдөгдөх эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд

- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-д Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 505 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр бүртгүүлсэн.

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 159 дүгээр тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоонд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг хүчингүй болгосон.

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын хэрэгжилт

- Хуульд заасны дагуу 2023 оны тайланг аудитаар баталгаажуулж ирүүлбэл зохих 173 ХЗХ-оос тайлант улирлын байдлаар 93.6 хувь буюу 162 ХЗХ жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

- ХЗХ-д Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй. 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар тусгай

зөвшөөрөлтэй 178 ХЗХ-ны 61.8 хувь буюу 110 ХЗХ зээлийн мэдээллийн санд хамрагдаж, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. Үүнээс 52.7 хувь буюу 58 ХЗХ нийслэлд, 47.3 хувь буюу 52 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

- 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 17 ХЗХ Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 23,223,583.98 мянган төгрөгийн 310 гүйлгээг мэдээлсэн бөгөөд сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

- 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлбэл зохих 86 ХЗХ 42,132.0 мянган төгрөгийг холбогдох дансанд бүрэн төвлөрүүлсэн байна.

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалтын хэрэгжилт

- Бүх гишүүдийн ээлжит хурлыг хуулийн хугацаанд зарлан хуралдуулж, хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх 173 ХЗХ-ны 99.4 хувь буюу 172 ХЗХ хууль болон нөхцөл, шаардлагаар хүлээсэн үүргийг биелүүлсэн байна.

ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 384 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын 2.1.16-д заасны дагуу Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос хадгаламж, зээлийн хоршоодын сонгуульт гишүүдэд 2024 оны 10 дугаар сарын 19, 28, 11 дүгээр сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хадгаламж, зээлийн хоршооны зээлийн үйл ажиллагаа” сэдэвт сургалтад “Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн тойм”, “Тогтвортой санхүүгийн суурь ойлголт, олон улсын чиг хандлага” сэдвээр мэдээлэл өгч, 135 оролцогчид гэрчилгээ олгосон.
- Бичил санхүүгийн бодлогын зөвлөлийн ээлжит хурлыг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хуралдуулж, салбарт авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ, хадгаламж, зээлийн хоршооны салбар дахь технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх судалгааг танилцуулж бодлогын зөвлөмж гаргуулсан.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 178 ХЗХ-оос 2024 оны 4 дүгээр улирлын тайлангийн нэгтгэлд 1 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан болно.

2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 4: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

| Статистик мэдээлэл | ХЗХ-ны нийт гишүүд | | Улаанбаатар хот | | Орон нутаг | |
|--|--------------------|---------------|-----------------|--------------|---------------|--------------|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| ХЗХ-дын тоо | 178 | 100.0% | 87 | 48.9% | 91 | 51.1% |
| Нийт гишүүдийн тоо | 75,252 | 100.0% | 40,363 | 53.6% | 34,889 | 46.4% |
| Эрэгтэй | 33,866 | 45.0% | 16,735 | 49.4% | 17,131 | 50.6% |
| Эмэгтэй | 41,072 | 54.6% | 23,395 | 57.0% | 17,677 | 43.0% |
| Гишүүн хуулийн этгээд | 314 | 0.4% | 233 | 74.2% | 81 | 25.8% |
| <i>Эмэгтэй удирдлагатай</i> | 124 | 39.5% | 82 | 66.1% | 42 | 33.9% |
| Гишүүдийн насжилт | 74,938 | 100.0% | 40,130 | 53.6% | 34,808 | 46.4% |
| 18-35 насны | 19,226 | 25.7% | 10,607 | 55.2% | 8,619 | 44.8% |
| 36-45 насны | 22,488 | 30.0% | 12,169 | 54.1% | 10,319 | 45.9% |
| 46-55 насны | 18,191 | 24.3% | 9,470 | 52.1% | 8,721 | 47.9% |
| 56-аас дээш | 15,033 | 20.1% | 7,884 | 52.4% | 7,149 | 47.6% |
| Гишүүдийн боловсрол | 74,938 | 100.0% | 40,130 | 53.6% | 34,808 | 46.4% |
| Дээд | 33,860 | 45.2% | 22,445 | 66.3% | 11,415 | 33.7% |
| Тусгай дунд | 11,318 | 15.1% | 6,579 | 58.1% | 4,739 | 41.9% |
| Бүрэн дунд | 18,636 | 24.9% | 8,986 | 48.2% | 9,650 | 51.8% |
| Дунд | 8,185 | 10.9% | 1,900 | 23.2% | 6,285 | 76.8% |
| Бага | 2,939 | 3.9% | 220 | 7.5% | 2,719 | 92.5% |
| Нийт ажилтнуудын тоо | 623 | 100.0% | 351 | 56.3% | 272 | 43.7% |
| <i>Үүнээс: Эмэгтэй</i> | 439 | 70.5% | 242 | 55.1% | 197 | 44.9% |
| Санхүүгийн програмтай | 93 | 52.2% | 35 | 37.6% | 58 | 63.4% |
| Монголбанкны СМА-нд 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо | 17 | 100.0% | 12 | 70.6% | 5 | 29.4% |
| Гүйлгээний тоо | 310 | 100.0% | 230 | 74.2% | 80 | 25.8% |
| Гүйлгээний дүн (мян.төг) | 23,223,583.98 | 100.0% | 20,636,812.17 | 88.9% | 2,586,771.81 | 11.1% |
| Монголбанкны СМА-нд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Сэжигтэй гүйлгээний тоо | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Сэжигтэй гүйлгээний дүн (мян.төг) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

2024 оны 4 дүгээр улиралд нийт ХЗХ-дын 9.6 хувь буюу 17 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 23,223,583.98 мянган төгрөгийн 310 гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх гүйлгээний дүнгийн 88.9 хувь буюу 20,636,812.17 мянган төгрөгийн 230 гүйлгээг Улаанбаатар хотын 12 ХЗХ, 11.1 хувь буюу 2,586,771.81 мянган төгрөг бүхий 80 гүйлгээг орон нутгийн 5 ХЗХ мэдээлсэн. Тайлант улирлын байдлаар сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

Нийт ХЗХ-дын 52.2 хувь буюу 93 ХЗХ санхүүгийн програм хангамжтай байна. Нийт 623 ажилтны 56.3 хувь буюу 351 нь Улаанбаатар хотын ХЗХ-нд, 43.7 хувь буюу 272 нь орон нутгийн ХЗХ-нд ажиллаж байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

| Статистик мэдээлэл | ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч | | Үүнээс: | | Орон нутаг | |
|---|---------------------------------|---------------|------------------------|---------------|----------------------|---------------|
| | Тоо | Хувь | Улаанбаатар хот Тоо | Хувь | Тоо | Хувь |
| ХЗХ-дын тоо | 178 | 100.0% | 87 | 48.9% | 91 | 51.1% |
| Нийт хадгаламжийн үлдэгдэл | 248,630,979.72 | 100.0% | 192,889,611.79 | 77.6% | 55,741,367.93 | 22.4% |
| Нийт хадгаламж эзэмшигчийн тоо | 45,579 | 100.0% | 24,117 | 52.9% | 21,462 | 47.1% |
| Иргэн | 45,508 | 99.8% | 24,085 | 99.9% | 21,423 | 99.8% |
| <i>Эмэгтэй</i> | 25,929 | 56.9% | 12,818 | 53.1% | 13,111 | 61.1% |
| Хуулийн этгээд | 71 | 0.2% | 32 | 0.1% | 39 | 0.2% |
| <i>Эмэгтэй удирдлагатай</i> | 43 | 0.1% | 10 | 0.0% | 33 | 0.2% |
| Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл | 5,271,505.43 | 2.1% | 4,389,360.56 | 2.3% | 882,144.87 | 1.6% |
| Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо | 6,135 | 13.5% | 4,707 | 19.5% | 1,428 | 6.7% |
| Иргэн | 6,109 | 13.4% | 4,687 | 19.4% | 1,422 | 6.6% |
| Хуулийн этгээд | 26 | 0.1% | 20 | 0.1% | 6 | 0.0% |
| Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл | 243,359,474.29 | 97.9% | 188,500,251.23 | 97.7% | 54,859,223.06 | 98.4% |
| Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо | 39,444 | 86.5% | 19,410 | 80.5% | 20,034 | 93.3% |
| Иргэн | 39,399 | 86.4% | 19,398 | 80.4% | 20,001 | 93.2% |
| Хуулийн этгээд | 45 | 0.1% | 12 | 0.0% | 33 | 0.2% |
| Хадгаламж эзэмшигчдийн насжилт | 45,508 | 100.0% | 24,085 | 100.0% | 21,423 | 100.0% |
| 18-35 насны | 16,606 | 36.5% | 10,877 | 45.2% | 5,729 | 26.7% |
| 36-45 насны | 10,911 | 24.0% | 4,856 | 20.2% | 6,055 | 28.3% |
| 46-55 насны | 9,501 | 20.9% | 4,433 | 18.4% | 5,068 | 23.7% |
| 56-аас дээш | 8,490 | 18.7% | 3,919 | 16.3% | 4,571 | 21.3% |
| Хадгаламж эзэмшигчдийн боловсрол | 45,508 | 100.0% | 24,085 | 100.0% | 21,423 | 100.0% |
| Дээд | 19,806 | 43.5% | 12,726 | 52.8% | 7,080 | 33.0% |
| Тусгай дунд | 6,344 | 13.9% | 3,100 | 12.9% | 3,244 | 15.1% |
| Бүрэн дунд | 9,694 | 21.3% | 3,827 | 15.9% | 5,867 | 27.4% |
| Дунд | 5,302 | 11.7% | 1,781 | 7.4% | 3,521 | 16.4% |
| Бага | 4,362.00 | 9.6% | 2,651 | 11.0% | 1,711 | 8.0% |

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 45,579 хадгаламж эзэмшигчийн 248,630,979.72 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 52.9 хувь буюу 24,117 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 77.6 хувь буюу 192,889,611.79 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 47.1 хувь буюу 21,462 хадгаламж эзэмшигч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 22.4 хувь буюу 55,741,367.93 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар зах зээлийн нийт хөрөнгө 356,780,082.71 мянган төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.4 хувь буюу 50,304,798.15 мянган төгрөгөөр өсөж, банкны зах зээлийн 0.5 хувьтай тэнцэж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 13.5 хувийг хугацаагүй, 86.5 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 45,508 нь хувь хүн (56.9 хувь буюу 25,929 нь эмэгтэй), 0.2 хувь буюу 71 нь хуулийн этгээд (0.1 хувь буюу 43 нь эмэгтэй удирдлагатай) байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,454.95 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,998.08 мянган төгрөг, орон нутагт 2,597.21 мянган төгрөг байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 23.7 хувь буюу 49,617,663.60 мянган төгрөгөөр, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 15.6 хувь буюу 33,471,101.08 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 20.5 хувь буюу 13,226,268.50 мянган төгрөгөөр, нийт зарлага 16.6 хувь буюу 8,887,626.36 мянган

төгрөгөөр нэмэгдэж нийт цэвэр орлого 15,295,012.14 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ

үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай нийт ХЗХ-дын 61.8 хувь буюу 110 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

| Үндсэн үзүүлэлтүүд | 2023 оны IV улирал | 2024 оны IV улирал | Өөрчлөлт Дүн | Хувь |
|--|-----------------------|-----------------------|----------------------|---------------|
| Нийт хөрөнгө | 306,475,284.56 | 356,780,082.71 | | |
| Банкны салбарт эзлэх хувь | 0.5% | 0.5% | 50,304,798.15 | 16.4% |
| Нийт зээл | 209,080,409.87 | 258,698,073.47 | | |
| Банкны салбарт эзлэх хувь | 0.8% | 0.7% | 49,617,663.60 | 23.7% |
| Нийт чанаргүй зээл | 6,675,552.76 | 6,061,902.80 | | |
| Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь | 3.2% | 2.3% | -613,649.96 | -9.2% |
| Банкны салбарт эзлэх хувь | 0.3% | 0.3% | -0.8% | -26.6% |
| | | | 0.0% | -1.1% |
| Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж | 215,159,878.63 | 248,630,979.72 | | |
| Банкны салбарт эзлэх хувь | 1.0% | 1.0% | 33,471,101.08 | 15.6% |
| Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө | 27,535,066.83 | 28,856,350.15 | | |
| Нийт хоршоологчдын өмч | 41,764,090.59 | 53,441,001.77 | 1,321,283.33 | 4.8% |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 3,324,514.76 | 2,953,387.57 | -371,127.19 | -11.2% |
| Нийт орлого | 64,625,037.33 | 77,851,305.84 | 13,226,268.50 | 20.5% |
| Нийт зарлага | 53,668,667.34 | 62,556,293.70 | 8,887,626.36 | 16.6% |
| Цэвэр орлого, алдагдал | 10,956,369.99 | 15,295,012.14 | 4,338,642.14 | 39.6% |

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 87 ХЗХ-ны нийт хөрөнгө 273,366,918.99 мянган төгрөг нь зах зээлийн 76.6 хувь, нийт зээл 191,863,274.31 мянган төгрөг нь зах зээлийн 74.2 хувь, нийт хадгаламж 192,889,611.79 мянган төгрөг нь зах зээлийн 77.6 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.9 хувь буюу 944,152.83 мянган төгрөгөөр буурч 5,007,537.33 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 2.6 хувийг эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 22.0 хувь буюу

10,502,859.11 мянган төгрөгөөр, нийт зарлага 15.6 хувь буюу 6,326,176.92 мянган төгрөгөөр, цэвэр орлого 58.0 хувь буюу 4,176,682.19 мянган төгрөгөөр өсөж 11,374,760.76 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 66.7 хувь буюу 58 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

| Үндсэн үзүүлэлтүүд | 2023 оны IV улирал | 2024 оны IV улирал | Өөрчлөлт Дүн | Хувь |
|--|-----------------------|-----------------------|----------------------|---------------|
| Нийт хөрөнгө | 239,239,093.34 | 273,366,918.99 | | |
| ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь | 78.1% | 76.6% | 34,127,825.65 | 14.3% |
| Нийт зээл | 156,644,871.60 | 191,863,274.31 | | |
| ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь | 74.9% | 74.2% | 35,218,402.71 | 22.5% |
| Нийт чанаргүй зээл | 5,951,690.17 | 5,007,537.33 | | |
| ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь | 89.2% | 82.6% | -944,152.83 | -15.9% |
| Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь | 3.8% | 2.6% | -6.5% | -7.3% |
| | | | -1.2% | -31.3% |

| | | | | |
|---|-----------------------|-----------------------|----------------------|--------------|
| Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж | 171,311,064.76 | 192,889,611.79 | 21,578,547.03 | 12.6% |
| ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь | 79.6% | 77.6% | -2.0% | -2.6% |
| Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө | 20,186,991.83 | 20,559,958.56 | 372,966.73 | 1.8% |
| ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь | 73.3% | 71.2% | -2.1% | -2.8% |
| Нийт хоршоологчдын өмч | 30,289,919.66 | 39,997,351.35 | 9,707,431.69 | 32.0% |
| ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь | 72.5% | 74.8% | 2.3% | 3.2% |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 3,035,679.92 | 2,826,918.12 | -208,761.79 | -6.9% |
| Нийт орлого | 47,707,346.38 | 58,210,205.49 | 10,502,859.11 | 22.0% |
| Нийт зарлага | 40,509,267.80 | 46,835,444.72 | 6,326,176.92 | 15.6% |
| Цэвэр орлого, алдагдал | 7,198,078.58 | 11,374,760.76 | 4,176,682.19 | 58.0% |

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 91 ХЗХ-ны нийт хөрөнгө 83,413,163.71 мянган төгрөг нь зах зээлийн 23.4 хувь, нийт зээлийн үлдэгдэл 66,834,799.16 мянган төгрөг нь зах зээлийн 25.8 хувь, нийт хадгаламж 55,741,367.93 мянган төгрөг нь зах зээлийн 22.4 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 16.1 хувь буюу 2,723,409.39 мянган төгрөгөөр, нийт зарлага 19.5 хувь буюу 2,561,449.44 мянган төгрөгөөр тус тус өсөж, нийт цэвэр орлого

3,920,251.37 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 57.1 хувь буюу 52 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 9: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

| Үндсэн үзүүлэлтүүд | 2023 оны IV | 2024 оны IV | Өөрчлөлт | |
|---|----------------------|----------------------|----------------------|---------------|
| | улирал | улирал | Дүн | Хувь |
| Нийт хөрөнгө | 67,236,191.22 | 83,413,163.71 | 16,176,972.49 | 24.1% |
| ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь | 21.9% | 23.4% | 1.4% | 6.6% |
| Нийт зээл | 52,435,538.26 | 66,834,799.16 | 14,399,260.89 | 27.5% |
| ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь | 25.1% | 25.8% | 0.8% | 3.0% |
| Нийт чанаргүй зээл | 723,862.59 | 1,054,365.46 | 330,502.87 | 45.7% |
| ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь | 10.8% | 17.4% | 6.5% | 60.4% |
| Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь | 0.5% | 0.5% | 0.1% | 18.9% |
| Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж | 43,848,813.88 | 55,741,367.93 | 11,892,554.05 | 27.1% |
| ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь | 20.4% | 22.4% | 2.0% | 10.0% |
| Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө | 7,348,075.00 | 8,296,391.60 | 948,316.60 | 12.9% |
| ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь | 26.7% | 28.8% | 2.1% | 7.7% |
| Нийт хоршоологчдын өмч | 11,474,170.93 | 13,443,650.43 | 1,969,479.50 | 17.2% |
| ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь | 27.5% | 25.2% | -2.3% | -8.4% |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 288,834.85 | 126,469.45 | -162,365.40 | -56.2% |
| Нийт орлого | 16,917,690.96 | 19,641,100.35 | 2,723,409.39 | 16.1% |
| Нийт зарлага | 13,159,399.54 | 15,720,848.97 | 2,561,449.44 | 19.5% |
| Цэвэр орлого, алдагдал | 3,758,291.42 | 3,920,251.37 | 161,959.96 | 4.3% |

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан. Журам шинэчлэн баталсантай холбоотойгоор хадгаламж болон зээлийг хүлээн зөвшөөрөх хэмжилтийн сууриуд, үнэ цэнийн өсөлт бууралт, хүүг хуримтлуулан

тооцох, шимтгэл хураамжийг хойшлуулан бүртгэх, тэнцлээс хасах, тэнцлээс хассан зээлийн орлогыг хүлээн зөвшөөрөх, эрсдэлийн санг СТОУС-ын дагуу ангилах, бүртгэлийн арга хандлагыг нарийвчлан зохицуулж, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх заавар, дансны жагсаалтыг шинээр боловсруулж, ерөнхий данс, үндсэн дансанд өөрчлөлт орсон тул дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц (мянган төгрөгөөр)

| ХӨРӨНГӨ | 2023 оны IV улирал | | ХӨРӨНГӨ | 2024 оны IV улирал | |
|---|-----------------------|--------------|---|-----------------------|--------------|
| | Дүн | Хувь | | Дүн | Хувь |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 302,433,000.65 | 98.7% | САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ | 345,093,989.79 | 96.7% |
| Мөнгөн хөрөнгө | 75,561,585.53 | 24.7% | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 74,119,672.16 | 20.8% |
| Бэлэн мөнгө | 3,700,642.83 | 1.2% | Бэлэн мөнгө | 4,062,665.43 | 1.1% |
| Банкинд байршуулсан харилцах | 14,687,071.64 | 4.8% | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах | 23,940,722.40 | 6.7% |
| Банкинд байршуулсан хадгаламж | 57,173,871.06 | 12.6% | Банканд байршуулсан хадгаламж | 45,591,655.34 | 12.8% |
| | | | Замд яваа мөнгө | 3,293.05 | |
| | | | Мөнгөтэй адилтгах хөрөнгө | - | 0.0% |
| | | | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 521,335.95 | 0.1% |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 900,000.00 | 0.3% | | | |
| Арилжааны үнэт цаас | 900,000.00 | 0.3% | | | |
| Зээл (цэвэр) | 204,238,272.48 | 66.6% | Зээл (цэвэр) | 264,849,735.30 | 74.2% |
| Нийт зээл | 209,080,409.87 | 68.2% | Нийт зээл | 258,698,073.47 | 72.5% |
| Хэвийн зээл | 193,870,730.72 | 63.3% | Хэвийн зээл | 245,093,924.37 | 68.7% |
| Хугацаа хэтэрсэн зээл | 8,534,126.39 | 2.8% | Хугацаа хэтэрсэн зээл | 7,542,246.30 | 2.1% |
| Чанаргүй зээл | 6,675,552.76 | 2.2% | Чанаргүй зээл | 6,061,902.80 | 1.7% |
| | | | Зээлийн хойшлогдсон орлого | 1157.521 | 0.0% |
| | | | Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 10,660,543.03 | 3.0% |
| (Зээлийн эрсдэлийн сан) | 4,842,137.38 | 1.6% | (Зээлийн эрсдэлийн сан) | 4,507,723.68 | 1.3% |
| | | | Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга | - | 0.0% |
| Авлага | 17,225,449.75 | 5.6% | | | |
| Байгууллага, хүмүүсээс авах авлага | 6,646,112.59 | 2.2% | | | |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 10,579,337.16 | 3.5% | | | |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 3,560,664.19 | 1.2% | Бусад санхүүгийн хөрөнгө | 6,124,582.33 | 1.7% |
| Татварын авлага | 56,684.46 | 0.0% | Дансны авлага (цэвэр) | 347,356.54 | 0.1% |
| Урьдчилж төлсөн зардал, тооцоо | 2,660,757.32 | 0.9% | Дансны авлага | 347,356.54 | 0.1% |
| Дараа тайлангийн тооцоо | 580,020.54 | 0.2% | Хувь хүнээс авах авлага | 344,189.01 | 0.1% |
| Дугагдал, шамшигдал | 125.66 | 0.0% | Хуулийн этгээдээс авах авлага (Авлагын эрсдэлийн сан) | 3,167.53 | 0.0% |
| Хангамжийн зүйлс | 263,076.22 | 0.1% | | - | 0.0% |
| Салбар хоорондын авлага | - | 0.0% | Холбоотой талаас авах авлага | 3,192,142.65 | 0.9% |
| | | | Ажиллагчдаас авах авлага | 21,425.78 | 0.0% |
| | | | Салбар хоорондын тооцоо | 93.30 | 0.0% |
| | | | Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгө (цэврээр) | 2,559,303.52 | 0.7% |
| | | | Бусад | 4,260.54 | 0.0% |

| | | | | | |
|---|-----------------------|---------------|---|-----------------------|---------------|
| Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр) | 947,028.69 | 0.3% | | | |
| Өмчлөх бусад хөрөнгө | 985,217.74 | 0.3% | | | |
| (Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга) | 38,189.05 | 0.0% | | | |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | 4,042,283.91 | 1.3% | САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ | 11,686,092.92 | 3.3% |
| Үндсэн хөрөнгө (цэвэр) | 3,887,594.18 | 1.3% | Татварын авлага | 437,665.10 | 0.1% |
| Биет бус хөрөнгө | 139,187.05 | 0.0% | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага | 214.83 | 0.0% |
| Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө | 15,502.69 | 0.0% | Урьдчилж төлсөн зардал тооцоо | 3,061,820.33 | 0.9% |
| | | | Бараа материал | 220,984.20 | 0.1% |
| | | | Өмчлөх бусад хөрөнгө (цэврээр) | 961,443.32 | 0.3% |
| | | | Бусад санхүүгийн бус хөрөнгө | 1,716,491.59 | 0.5% |
| | | | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (цэврээр) | - | 0.0% |
| | | | Үндсэн хөрөнгө (цэврээр) | 4,485,685.42 | 1.3% |
| | | | Биет бус хөрөнгө (цэврээр) | 801,788.13 | 0.2% |
| ХӨРӨНГИЙН ДҮН | 306,475,284.56 | 100.0% | ХӨРӨНГИЙН ДҮН | 356,780,082.71 | 100.0% |

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 356,780,082.71 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.4 хувь буюу 50,304,798.15 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 96.7 хувийг санхүүгийн хөрөнгө, 3.3 хувийг санхүүгийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт хөрөнгийн 20.8 хувийг, цэвэр зээл 74.2 хувийг тус тус эзэлж байна. Зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.7 хувиар өссөн байна.


Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс (мянган төгрөгөөр)



Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23.7 хувь буюу 49,617,663.60 мянган төгрөгөөр өсөж 258,698,073.47 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 4,507,723.68 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.6 хувь буюу 991,880.09 мянган төгрөгөөр буурч 7,542,246.30 мянган төгрөг, чанаргүй зээл 9.2 хувь буюу 613,649.96 мянган төгрөгөөр буурч 6,061,543.03 мянган төгрөг болсон үзүүлэлттэй байна.

График 6: Нийт хөрөнгийн бүтэц



ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2022 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар буурсан боловч дунджаар 10.4 хувиар өссөн. Нийт зээлийн хэмжээ дунджаар 11.2 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ дунджаар 0.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгө, зээлийн багцын өөрчлөлт (тэрбум төгрөгөөр)


| | 2020.IV | 2021.IV | 2022.IV | 2023.IV | 2024.IV | Дүрслэл |
|---------------|---------|---------|---------|---------|---------|---------|
| ХЗХ-ны тоо | 249 | 209 | 196 | 191 | 178 | |
| Нийт хөрөнгө | 256.0 | 291.2 | 267.7 | 306.5 | 356.8 | |
| Нийт зээл | 167.6 | 213.4 | 210.2 | 209.1 | 258.7 | |
| Чанаргүй зээл | 7.4 | 7.4 | 7.0 | 6.7 | 6.1 | |

3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 200,504,424.76 мянган төгрөг ба зах зээлийн нийт хөрөнгийн 56.2 хувийг, гишүүдийн тоо 19,578 байгаа нь нийт гишүүдийн 26.0 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар (мянган төгрөгөөр)

| № | Хөрөнгийн хэмжээ | ХЗХ-дын тоо | Нийт хөрөнгө | | Гишүүд | |
|-----------------|---------------------------|-------------|-----------------------|---------------|---------------|---------------|
| | | | Дүн | Хувь | Тоо | Хувь |
| 1 | 10,000,000.0-аас дээш | 4 | 200,504,424.76 | 56.2% | 19,578 | 26.0% |
| 2 | 1,000,000.0 -10,000,000.0 | 35 | 120,650,543.08 | 33.8% | 30,792 | 40.9% |
| 3 | 500,000.0-1,000,000.0 | 25 | 17,830,847.96 | 5.0% | 10,049 | 13.4% |
| 4 | 100,000.0-500,000.0 | 67 | 14,987,370.04 | 4.2% | 11,424 | 15.2% |
| 5 | 50,000.0-100,000.0 | 29 | 2,306,015.07 | 0.6% | 2,440 | 3.2% |
| 6 | 10,000.0-50,000.0 | 15 | 483,973.42 | 0.1% | 859 | 1.1% |
| 7 | 10,000.0 хүртэл | 3 | 16,908.37 | 0.00% | 110 | 0.1% |
| Нийт дүн | | 178 | 356,780,082.71 | 100.0% | 75,252 | 100.0% |



3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 258,698,073.47 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 72.5 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 264,849,735.30 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 74.2 хувийг тус тус эзэлж байна. Нягтлан бодох бүртгэлийн журам шинэчлэгдсэнээр цэвэр зээлийн үндсэн дансанд хамаарах бусад нэрийн дансуудыг нэмэгдсэнээр тооцоолсон болно.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.37 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.06 хувь байгаа бол Улаанбаатар хотын ХЗХ-дын жигнэсэн дундаж хүү 2.27 хувь, орон нутгийн ХЗХ-дын жигнэсэн дундаж хүү 2.65 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 34 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 88.0 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 13: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар (мянган төгрөгөөр)

| № | Зээлийн хэмжээ | ХЗХ-дын тоо | Зээлийн дүн | Эзлэх хувь |
|-----------------|---------------------------------|-------------|-----------------------|-------------|
| 1 | 1,000,000.0 дээш | 34 | 227,542,635.72 | 88.0% |
| 2 | 500,000.0-1,000,000.0 | 20 | 13,726,225.38 | 5.3% |
| 3 | 100,000.0-500,000.0 | 66 | 14,633,879.96 | 5.7% |
| 4 | 50,000.0-100,000.0 | 31 | 2,149,156.66 | 0.8% |
| 5 | 10,000.0-50,000.0 | 20 | 637,777.35 | 0.2% |
| 6 | 10,000.0 хүртэл | 3 | 8,398.39 | 0.0% |
| 7 | Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй | 4 | - | - |
| Нийт дүн | | 178 | 258,698,073.47 | 100% |

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 14: Зээлийн ангиллын мэдээлэл (мянган төгрөгөөр)

| Зээлийн ангиллын мэдээлэл | Зээлдэгчийн мэдээлэл | | Зээлийн үлдэгдэл | |
|---------------------------|----------------------|---------------|-----------------------|---------------|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| Нийт | 28,918 | 100.0% | 258,698,073.47 | 100.0% |
| Хэвийн | 27,029 | 93.5% | 245,093,924.37 | 94.7% |
| Хугацаа хэтэрсэн | 741 | 2.5% | 7,542,246.30 | 2.9% |
| Чанаргүй | 1,148 | 4.0% | 6,061,902.80 | 2.4% |
| <i>Хэвийн бус</i> | 319 | 27.8% | 1,710,073.79 | 28.2% |
| <i>Эргэлзээтэй</i> | 285 | 24.8% | 1,566,799.46 | 25.8% |
| <i>Муу</i> | 544 | 47.4% | 2,785,029.54 | 46.0% |

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 94.7 хувь буюу 245,093,924.37 мянган төгрөгийг хэвийн зээл, 2.9 хувь буюу 7,542,246.30 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 2.4 хувь буюу 6,061,902.80 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 13,604,149.10 мянган төгрөгийн үлдэгдэлд 33.1 хувь буюу 4,507,723.68 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна. Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 93.5 хувийг хэвийн, 2.5 хувийг хугацаа хэтэрсэн, 4.0 хувийг чанаргүй зээлдэгч эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,148 зээлдэгчийн 6,061,902.80 мянган төгрөгийн үлдэгдлийн 28.2 хувийг

Хүснэгт 15: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар (мянган төгрөгөөр)


| Зээлийн ангиллын мэдээлэл | Улаанбаатар хот | | | Орон нутаг | | |
|---------------------------|-----------------------|---------------|----------------------|----------------------|---------------|----------------------|
| | Дүн | Хувь | Нийт дүнд эзлэх хувь | Дүн | Хувь | Нийт дүнд эзлэх хувь |
